

**ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНД 2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГДСЭН ТАЙЛАНД ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ**

2019 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зөвлөмж	Гүйцэтгэл	Хувь
1	Техник хяналтын актгүй автомашины засвар үйлчилгээнд 10.4 сая төгрөгийг зарцуулсан байна.	Аудитын зөвлөмжийн дагуу Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тогтоолын хавсралт 9, 11-т заасныг мөрдөж ажиллаж байна.	100
2	Тус хүрээлэнгийн захирлын 2018 оны нэг удаагийн буцалтгүй тусламжийн тушаалын үндэслэл нь хөдөлмөрийн дотоод журмын 12 дугаар бүлэгт заасантай зөрчилдөж байна. Дээрх тушаалуудаар нийт 17.5 сая төгрөгийг зарцуулсан байна.	Аудитын зөвлөмжийн дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2016 оны А/07 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын дагуу албан хаагчдад олгох тусламж тэтгэмжийн тушаалыг гарган ажиллаж байна.	100
3	Нийт 5.4 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн байна.	Аудитын зөвлөмжийн дагуу Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу аливаа ажил гүйлгээг тооцоо үүсгэн бүртгэн ажиллаж байна.	100
4	Нэр бүхий 2 байгууллагатай нийт 42.8 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч тус гэрээг дүгнэсэн акт, тэмдэглэл үйлдээгүй байна. Цаашид аливаа гэрээг дүгнэж акт, тэмдэглэл хөтөлж гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.	Аудитын зөвлөмжийн дагуу аливаа гэрээг харилцагч байгууллагуудтай байгуулаад барааг хүлээж авсаны дараа гэрээг дүгнэж акт үйлдэж ажиллаж байна.	100

5	Ажиллагсдын цалингаас байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй 21.7 сая төгрөгийн суутгал суутгасан байна. Тухайлбал: Мобиком, Жи Мобойлд ажилтнуудын гар утасны төлбөрийг суутгасан байна.	Аудитын зөвлөмжийн дагуу ажиллагсдын цалингаас аливаа суутгал суутгалгүй ажиллаж байна.	100
6	Нийт 14.1 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. Үүнд: Эм бэлдмэлийн зардлаас 2.1 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээс 0.4 сая төгрөг, урсгал засвараас 0.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 11.2 сая төгрөгөөр тус тус бэлтгэсэн байна.	Аудитын зөвлөмжийн дагуу Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын дагуу сар улирлын хуваарьт өөрчлөлт хийн урсгал зардлаас хөрөнгө бэлдэхгүй байхад анхааран ажиллаж байна.	100
7	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн аймаг, нийслэлийн салбар байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 17.5 сая төгрөгийн 21 зөвлөмж, 5.0 сая төгрөгийн 4 албан шаардлага, 3.7 сая төгрөгийн 6 акт тогтоосон байна. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, актыг хэрэгжүүлж ажиллах, тогтоосон хугацаанд хэрэгжилтийг хүргүүлэх.	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн аймаг, нийслэлийн салбар байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 17.5 сая төгрөгийн 21 зөвлөмж, 5.0 сая төгрөгийн 4 албан шаардлага, 3.7 сая төгрөгийн 6 акт тогтоосон бөгөөд Аудитаас өгсөн зөвлөмж, албан шаардлага, актыг тогтоосон хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг тухай бүрт явуулсан болно.	100